Сүхбаатар аймгийн ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүхбаатар аймгийн ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургууль нь “Багш ажилтан бүр хүүхдийн хөгжил, хүмүүжил төлөвшил оролцоог бүх талаар дэмжин чанартай хүртээмжтэй, өндөр бүтээмжтэй сургалтыг тасралтгүй зохион байгуулахыг эрхэмлэнэ.” гэсэн эрхэм зорилготой байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 2,850.4 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 28.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 22.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар аймгийн ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 24.3 сая төгрөгөөр буюу 1.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
Авлага	20.6	12.1	-8.5
Бараа материал	128.9	138.6	9.7
Үндсэн хөрөнгө	1,404.8	1,379.2	-25.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,554.3</b>	<b>1,529.9</b>	<b>-24.3</b>
Өр төлбөр	16.0	0.00	-16.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,300.6	1,300.6	0.00
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,554.3</b>	<b>1,529.9</b>	<b>-24.3</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 138.6 сая төгрөг болж 9.7 сая төгрөгөөр өссөн нь эм боох материал 0.1 сая, бусад хангамжийн материал 3.1 сая, мал амьтад үнийн зөрүүнээс 24.7 сая, нийт 27.9 сая төгрөгөөр үлдэгдэл өссөн, тусгай зориулалтын материал 1.7 сая, бичиг хэргийн материал 1.0 сая, нийт 2.7 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,529.9 сая төгрөг болж 24.3 сая төгрөгөөр буурсан нь БШУЯам, дэлхийн банкны төслөөр “Боловсролын чанарын шинэчлэл” төслөөс тоног төхөөрөмж 10.3 сая, тавилга, хэрэгсэл 4.9 сая, номын хэрэглэгдэхүүн 8.9сая, нийт 24.2 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй шилжиж ирсэн бөгөөд төсвийн хөрөнгөөр 23.8

сая төгрөг, нийт 48.0 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, Аймгийн орон нутгийн өмчийн газрын 2021 оны 622 тоот албан бичгээр 297.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө данснаас хасагдаж, 72.0 сая төгрөгийн элэгдлийн зардлаар хөрөнгө буурсан байна.

Авлагын дансны үлдэгдэл 12.1 сая төгрөг болж буурсан нь өмнөх онд захиргаа удирдлагын ажилчин албан хаагч нарт өндөр дүнтэй урьдчилгаа олгож дутуу суутгасан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,529.9 сая төгрөг болж 8.3 сая төгрөгөөр буурсан байна.

Сүхбаатар аймгийн ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 8.9 сая төгрөгөөр буюу 0.8 хувиар өссөн нь улсын төсвөөс санхүүжих 110.8 сая, нэмэлт санхүүжилтийн орлого 8.7 сая, нийт 119.5 сая төгрөгөөр нэмэгдсэн, мөн үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 92.1 сая, орон нутгийн санхүүжилт 18.4 сая, төгрөгөөр буурсан тус тус нөлөөлжээ.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт, дээд шатын төсөв захирагчаас үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 115.1 сая төгрөг буюу 4.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь ковид-19 цар тахалтай холбоотой цалин, НДШ, эмийн зардал, ариутгал халдваржуултал, тээвэр шатахуун, нэг удаагийн тэтгэмжийн зардлууд нэмэгдсэнтэй холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,153.8 сая төгрөгөөр, нийт зарлагыг 3,153.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,906.5 сая төгрөгийн төсөв баталснаас 2,554.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 351.8 сая төгрөгийг орон төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 2,554.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 351.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс зарцуулж, нийт 2,906.7 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулж, 0.5 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,906.0 сая төгрөг буюу 99.4 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсөв захирагчаас 31.4 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 8.8 сая, олон улсын төсөл арга хэмжээний санхүүжилт 12.9 сая нийт 53.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс эд хогшил, урсгал засварын зардал 19.0 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 8.3 сая, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх 8.3 сая бичиг хэрэг ном худалдан авах, нэг удаагийн тэтгэмж урамшуулал 17.6 сая, нийт 53.2 сая төгрөгийн гүйцэтгэл гарчээ.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Сүхбаатар аймгийн ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, цалингийн урьдчилгааг сард авах хэмжээнээс хэтрүүлэн удаа дараа өөртөө олгосон байна. Цалингийн зардлаас хууль эрх зүйн үндэслэлгүй гэрээ байгуулж, төсвийг зориулалт бус зарцуулсан бөгөөд хийгдээгүй ажилд хөрөнгө шилжүүлж, төсвийн үлдэгдлийг төвлөрүүлээгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 148 мэдээлэл, хугацаа хоцорч 1 мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолоор төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан байна. Тухайлбал:

- Тогтоолын 1.1-д “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй

хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”

- Тогтоолын 1.8-д “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах; гэж заасан байна”

Сангийн яамнаас 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн “Тодруулга хүргүүлэх тухай” Н-3/845 дугаар албан бичгийг Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна. Тус албан бичигт “Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д заасан “үндсэн үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй шаардлагатай зардал, төсөл, арга хэмжээ” гэдэгт төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор ажилтан, албан хаагчдад төлж байгаа цалин хөлс, олговор, ажил олгогчоос төлөх нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, цахилгаан, халаалт, цэвэр, бохир ус, түрээсийн зардал болон байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой шаардлагатай бусад зардал хамаарна.” гэж тодруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 37.6 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн актын 27.5 сая төгрөгийг хэрэгжүүлж, 2 зөвлөмж, 10.1 сая төгрөгийн төлбөрийн актыг биелүүлээгүй байна.

Хүснэгт 2 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/сая.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	5	37.6	4	10.1	1	27.5	73.1
Албан шаардлага	-	-	-	-	-	-	-
Зөвлөмж	2	-	-	-	2	-	100
Нийт дүн	7	37.6	4	10.1	3	27.5	73.1

Өмнөх оны хэрэгжүүлээгүй зөвлөмжийг албан шаардлага болгож, төлбөрийн актыг бүрэн төлж дуусгах талаар танилцуулаа.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар аймгийн ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургуулийн тайлант оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, ажил гүйлгээ болон санхүүгийн тайланг тасалбар болгож гаргасан өдрөөс хойших үйл явдлыг шинжилж үзэхэд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

## 10. 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 40.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, сая төгрөгийн зөрчилд 12.5 сая төлбөрийн акт тогтоож, 25.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 1 асуудалд зөвлөмж өгч, 2 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулаа

#### 4.1 ТӨЛБӨРИЙН АКТ

4.1.1 Хоолны зардлаас хэмнэгдсэн, төсвийн хэмнэлтэд тооцогдохгүй төсвийн үлдэгдэл 1.0 сая төгрөгийг төсвийн нэгдсэн дансанд төвлөрүүлэлгүй, хүнсний материал нөөцөлсөн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 /Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ./, 41 дүгээр зүйлийн 41.2.3 /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах./, 45 дугаар зүйлийн 45.2 /Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ/ дахь заалт болон тасалбар болголт, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

4.1.2 Цалингийн урьдчилгааг сард олговол зохих хэмжээнээс хэтрүүлэн 4.5 сая төгрөгөөр олгож, 1.9 сая суутгаагүй авлагаар илэрхийлж, төсвийн үлдэгдлийг төвлөрүүлээгүй зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах./, 6.4.8/ төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх/, 41 дүгээр зүйлийн 41.2.3 /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах./, 45.2 /Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ/ дахь заалт болон иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдэлтэй нийцэхгүй .

4.1.3 Цалингийн сангаас 2 дугаар байрны дээврийн засварт 3.0 сая төгрөг багш ажилчдын эрүүл мэндийг дэмжихэд “fohow” аппаратаар үйлчилгээ үзүүлэх 4.1 сая, нийт 7.1 сая төгрөгийн хууль эрх зүйн үндэслэлгүй гэрээ байгуулж, төсвийг зориулалт бус зарцуулсан бөгөөд хийгдээгүй ажилд хөрөнгө шилжүүлж, төсвийн үлдэгдлийг төвлөрүүлээгүй зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах./, 16 дугаар зүйлийн 16.5.5. /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, 41 дүгээр зүйлийн 41.2.3 /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах./, 45 дугаар зүйлийн 45.2 /Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ/ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13./ Санхүүгийн тайлангийн жил 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхэлж 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно/ дахь заалт, Сангийн сайдын 2021оны 190 тушаал болон эрх үүрэг иж бүрэн байх, тасалбар болголт батламж мэдэгдэлтэй нийцэхгүй.

4.1.4 Сургалтын менежер томилолтоор ажилласан газраар албан томилолтын хуудсыг хаалгаагүй, баримт нь нотлогдоогүй байхад 0.2 сая төгрөгийг олгосон зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах./, 41 дүгээр зүйлийн 41.2.3 /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах/ дахь заалт болон иж бүрэн байх, толилуулга батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

4.1.5 Сургалтын удирдлагын “moodle sols” системийг сургалт хийх зардлын хамт 5.0 сая төгрөгөөр “ICT” компанитай гэрээ байгуулж худалдан авсан. Гэтэл Боловсролын газрын мэргэжилтэнтэй тус программыг нэвтрүүлэхтэй холбоотой цалингийн сангаас сургалтын зардалд 2.0 сая төгрөгийн гэрээ байгуулж, төсвийг зориулалт бус зарцуулсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах./, 16 дугаар зүйлийн 16.5.5. /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, 41 дүгээр зүйлийн 41.2.3 /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах./, 45 дугаар зүйлийн 45.2 /Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ/ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13./ Санхүүгийн тайлангийн жил 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхэлж 12 дугаар сарын 31-ний

өдрөөр дуусгавар болно/ дахь заалт, Сангийн сайдын 2021оны 190 тушаал болон иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

## 4.2 АЛБАН ШААРДЛАГА

4.2.1 Тооллогын комисс эд хөрөнгө нэг бүрийг бодитой, үнэн зөв тооллого хийгээгүй, тооллогын дүнг нягтлан бодогчтой тулгаж баталгаажуулаагүй зөрчил илэрлээ. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1<sup>1</sup>, 72.4.2<sup>2</sup>, 72.4.4<sup>3</sup>, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6<sup>4</sup> дахь заалттай нийцэхгүй байна

4.2.2 Тээвэр шатахууны зарцуулалтад замын хуудсыг бүрэн, тодорхой, иж бүрэн хөтлөөгүй, дотоод хяналт сул, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулаагүй зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1/ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, 6.4.2 /төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх/, 16 дугаар зүйлийн 16.5.5 /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/ заалт, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалтай нийцэхгүй байна.

4.2.3 Бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас худалдан авсан бараа, ажил үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.21-т заасан хэрэглэгчийн системтэй этгээдээс худалдан авалт хийсэн боловч төлбөрийн баримтыг хавсраагүй, өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж хэрэгжээгүй зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1/ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, 6.4.2 /төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх/ заалт, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалтай нийцэхгүй байна.

4.2.4 Хичээл, үйлдвэрлэл, хоолны хүнсний зардлаас 14.2 сая төгрөгийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1/ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, 6.4.2 /төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх/, 16 дугаар зүйлийн 16.5.5 /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/ заалт, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалыг зөрчсөн зөрчил илэрлээ. Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор Ковид-19 цар тахлын нөхцөлд төсвийг үр ашигтай зарцуулж, хэмнэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг баталсан. Уг тогтоолыг баримтлалгүй шинээр ажлын байр 1-ээр нэмэгдүүлсэн, залуу багш нарын чуулга уулзалт, бичгийн цаас принтерийн хорны хэрэглээ зэрэгт нийт 11.2 сая төгрөгийг зарцуулсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1/ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, 6.4.2 /төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх/, 16 дугаар зүйлийн 16.5.5 /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/ заалт, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

### 4.2.5 Сахилгын шийтгэл тооцуулах тухай

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, цалингийн урьдчилгааг сард авах хэмжээнээс хэтрүүлэн удаа дараа өөртөө олгосон, батлагдсан зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ хийсэн, үдийн цайны зардалд худалдан авах тендер зарлаагүй, төсөвт төвлөрүүлбэл зохих

<sup>1</sup> эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах;

<sup>2</sup> тоолсон эд хөрөнгийн үнийг бэлтгэн нийлүүлэгчийн дагалдах баримт, тухайн үеийн зах зээлийн үнийн жишигтэй тулган шалгаж, тооллогын бүртгэлд бичих;

<sup>3</sup> комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх;

<sup>4</sup> эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;

үлдэгдлийг хувь хүнтэй хүчин төгөлдөр бус гэрээ байгуулж шилжүүлсэн, эдгээр зөрчил нь санхүүгийн тайланд материаллагаар өргөн тархсан учир сөрөг санал дүгнэлт өгөв. Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 /Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно/ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, 16 дугаар зүйлийн 16.5.5 /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, дахь заалттай нийцэхгүй байгаа тул захирал Ц.Оюунжаргалд сахилгын шийтгэл тооцуулах тухай албан шаардлага хүргүүлэв.

4.2.6 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, батлагдсан зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ хийсэн, төсвийн төвлөрүүлэх үлдэгдлийг хувь хүний дансанд шилжүүлсэн зөрчил илэрлээ. Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 /Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно/ дахь, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, 16 дугаар зүйлийн 16.5.5 /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, 41 дүгээр зүйлийн 41.2.3 /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах/, Нягтлан бодох тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 /хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх/, 20.2.5 /дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах/, 20.2.6 /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/ дахь заалттай нийцэхгүй байгаа тул нягтлан бодогч Ю.Оюунтунгалагт сахилгын шийтгэл тооцуулах тухай албан шаардлага хүргүүлэв.

### **4.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **4.3.1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

##### **4.3.1. Илрүүлэлт:**

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 293 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан "Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана" заалттай нийцэхгүй байна.

##### **4.3.1. Өгсөн зөвлөмж:**

Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

#### **4.3.2. Түлш халаалтын зардалтай холбоотой асуудал**

##### **4.3.2. Илрүүлэлт:**

Байгууллагын барилгад дулааны тоолуур суурилуулаагүй нь Засгийн газрын 2020 оны 144 дүгээр тогтоолын 1 дэх “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөвт байгууллагын дулааны эрчим хүчний хэрэглээг хэмжүүрээр тооцох нөхцөлийг бүрдүүлж, тоолуур суурилуулах ажлыг 2020 оны 3-р улиралд багтаан зохион байгуулж, хэрэгжүүлэхийг төсвийн захирагч, гүйцэтгэх удирдлага нарт үүрэг болгосугай” заалттай нийцэхгүй байна.

**4.3.2. Өгсөн зөвлөмж:**

Байгууллагын барилгад дулааны тоолуур суурилуулж, дулааны эрчим хүчний төлбөрийг Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 10 сарын 14-ний өдрийн 461 дүгээр тогтоолоор батлагдсан “Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф”-ыг мөрдөж, Засгийн газрын 2020 оны 144 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**11. 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сүхбаатар аймгийн ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургуулийн	13	40.8	-	-	5	12.5	6	28.3	2	-